

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/044-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn</p> <p>Сүхбаатар сум</p> <p>2025 он</p>	<p>Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13-14
4. Аудитын тайлан	14-17
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДЕГ	Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг Цагаан эрэн Сүхбаатар сум
Сэлэнгэ аймаг 43081
Утас/Факс: (976) 7036 3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
С.ОТГОНЖАРГАЛ ТАНАА**

2025.02.14 № СЭА-2025/044-НА-СТА-ТШЗ

танай

-ны №

-1

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус газар нь хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдэлд 26 албан хаагчид нийт 171,859.1 мянган төгрөг олгосон байна.

Аудитын гол асуудал

НДЕГ-ын даргын 2024 оны А/51 дүгээр тушаалаар Мандал, Сайхан сумдын нийгмийн даатгалын сан хариуцсан нягтлан бодогчийн ажлын байрыг цомхотгосноор аймгийн НДГ-ын сангийн нягтлан бодогчид бүх ажил гүйлгээг гүйцэтгэж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус хэлтэс нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг 91.4 хувьтай үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,570,572.4	25,124,378.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	949,000.0	949,000.0
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	949,000.0	949,000.0
31210	Төгрөг	949,000.0	949,000.0
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	949,000.0	949,000.0
33	АВЛАГА	102,258.4	1,077,139.4
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	974,881.0
33500	Бусад авлага	102,258.4	102,258.4
33520	Хувь хүмүүсээс авах авлага	102,258.4	102,258.4
35	БАРАА МАТЕРИАЛ	16,519,314.0	23,098,239.0
35400	Хангамжийн материал	16,519,314.0	23,098,239.0
35410	Бичиг хэргийн материал	3,304,500.0	1,233,500.0
35420	Аж ахуйн материал	10,505,200.0	12,182,800.0
35430	Сэлбэг хэрэгсэл	859,800.0	7,734,300.0
35440	Түлш, шатах тослох материал	408,506.0	509,241.0
35470	Бусад хангамжийн материал	1,441,308.0	1,438,398.0
3695	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,294,414,812.7	1,248,839,464.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,294,414,812.7	1,248,839,464.9
39200	Биет хөрөнгө	1,279,977,612.7	1,234,402,264.9
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,387,219,740.1	1,387,219,740.1
39202	Хуримтлагдсан элэгдэл	(203,660,216.8)	(235,003,412.1)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,540,000.0	12,540,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,016,000.0)	(7,524,000.0)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	132,219,620.7	141,532,806.9
39206	Хуримтлагдсан элэгдэл	(59,353,249.4)	(81,111,116.3)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	112,116,628.4	103,947,848.4
39208	Хуримтлагдсан элэгдэл	(96,088,910.3)	(87,199,602.2)
39300	Биет бус хөрөнгө	14,437,200.0	14,437,200.0
39303	Бусад биет бус хөрөнгө	14,437,200.0	14,437,200.0
395	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,311,985,385.1	1,273,963,843.2
40	НИЙТ ӨР ТӨЛБӨР	102,018.4	102,018.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	102,018.4	102,018.4
41300	Өглөг	102,018.4	102,018.4
41360	Бусад өглөг	102,018.4	102,018.4
41361	Байгууллагад төлөх өглөг	102,018.4	102,018.4
50	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,311,883,366.7	1,273,861,824.8
51	Засгийн газрын хувь оролцоо	1,311,883,366.7	1,273,861,824.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	349,539,030.0	349,539,030.0
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	349,539,030.0	349,539,030.0
51200	Хуримтлагдсан үр дүн	826,820,582.7	788,799,040.9
51210	Өмнөх үеийн үр дүн	826,820,582.7	826,820,582.7
51220	Тайлант үеийн үр дүн	-	(38,021,541.9)
51300	Хөрөнгийн дажин үнэлгээний зөрүү	135,523,753.9	135,523,753.9
60	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,311,985,385.1	1,273,963,843.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,682,707,966.2	2,378,879,309.3
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,485,314.2	11,144,805.4
3	Нийтлэг татварын бус орлого	1,485,314.2	11,144,805.4
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,485,314.2	11,144,805.4
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,485,314.2	8,730,605.4
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	2,414,200.0
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,681,222,652.0	2,367,734,503.9
8	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,975,000.0	210,386,703.9
9	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,975,000.0	208,346,703.9
10	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,040,000.0
11	Төсвийн захирагчдаас	4,528,752.0	2,157,347,800.0
12	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,157,347,800.0
13	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,528,752.0	-
14	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,667,718,900.0	-
15	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,667,718,900.0	-
16	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,754,106,449.0	2,416,900,851.2
17	УРСГАЛ ЗАРДАЛ	1,754,106,449.0	2,416,900,851.2
18	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,614,698,633.3	2,127,602,112.0
19	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,111,840,389.4	1,700,294,659.0
20	Үндсэн цалин	692,519,759.2	870,174,702.6
21	Нэмэгдэл	271,020,312.5	621,448,339.2
22	Унаа хоолны хөнгөлөлт	34,251,406.0	57,274,062.4
23	Урамшуулал	114,048,911.7	151,397,554.9
24	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,978,012.4	212,248,870.1
25	Тэтгэврийн даатгал	95,290,209.3	145,823,749.4
26	Тэтгэмжийн даатгал	11,211,883.0	17,514,629.5
27	ҮОМШӨ-ний даатгал	9,538,905.8	8,538,705.8
28	Ажилгүйдлийн даатгал	2,079,597.5	7,917,087.5
29	Эрүүл мэндийн даатгал	20,857,416.9	32,454,698.0
30	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,893,209.3	77,824,952.3
31	Гэрэл, цахилгаан	6,141,370.8	7,861,181.3
32	Түлш, халаалт	62,231,410.5	66,674,658.0
33	Цэвэр, бохир ус	2,520,428.0	3,289,113.0
34	Хангамж, бараа материалын зардал	36,004,280.7	25,617,277.3
35	Бичиг хэрэг	13,087,700.0	11,531,250.0
36	Тээвэр, шатахуун	6,631,961.0	5,553,005.0
37	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,141,477.2	2,295,012.3
38	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	568,000.0	1,150,000.0
39	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,993,600.0	5,088,010.0
40	Бараа материал акталсны зардал	581,542.5	-
41	Эд хогшил, урсгал засварын зардал	146,613,686.0	23,685,616.0
42	Багаж, техник, хэрэгсэл	770,000.0	2,850,000.0
43	Урсгал засвар	145,843,686.0	20,835,616.0
44	Томиллолт, зочны зардал	13,778,900.0	17,696,800.0
45	Дотоод албан томиллолт	13,778,900.0	17,696,800.0
46	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,753,437.0	4,080,484.0
47	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,173,000.0	1,147,350.0
48	Даатгалын үйлчилгээ	494,250.0	500,000.0
49	Тээврийн хэрэгслийн татвар	52,700.0	10,100.0
50	Газрын төлбөр	10,343.0	12,004.0
51	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	535,920.0
52	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,023,144.0	1,875,110.0

53	Бараа үйлчилгээний бусад зардал	90,836,718.5	66,153,453.3
54	Бараа үйлчилгээний бусад зардал	8,975,000.0	150,000.0
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,262,500.0	1,858,600.0
56	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	80,599,218.5	64,144,853.3
57	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,407,815.8	289,298,739.2
58	Бусад урсгал шилжүүлэг	39,432,660.0	234,258,154.4
59	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,191,760.0	56,906,288.4
60	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,240,900.0	-
61	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	175,351,866.0
62	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,000,000.0
63	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	55,040,584.8
64	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	50,386,130.3
65	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,654,454.4
66	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	99,975,155.8	-
67	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,975,155.8	-
68	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (I)-(II)	(71,398,482.8)	(38,021,541.9)
69	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(71,398,482.8)	(38,021,541.9)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	1,722,966,966.6	2,367,854,503.9
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,273,066.6	120,000.0
3	Нийтлэг татварын бус орлого	46,273,066.6	120,000.0
4	Бусад орлого	46,273,066.6	120,000.0
5	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,676,693,900.0	2,367,734,503.9
6	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,975,000.0	210,386,703.9
7	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,975,000.0	208,346,703.9
8	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,040,000.0
9	Төсвийн захирагчдаас	-	2,157,347,800.0
10	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,157,347,800.0
11	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,667,718,900.0	-
12	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,667,718,900.0	-
13	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,719,465,573.0	2,358,015,603.9
14	УРСГАЛ ЗАРДАЛ	1,719,465,573.0	2,358,015,603.9
15	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,583,218,636.1	2,068,716,864.7
16	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,111,840,389.4	1,701,269,540.0
17	Үндсэн цалин	692,519,759.2	870,174,702.6
18	Нэмэгдэл	271,020,312.5	621,448,339.2
19	Унаа хоолны хөнгөлөлт	34,251,406.0	57,274,062.4
20	Урамшуулал	114,048,911.7	152,372,435.9
21	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,637,497.6	212,248,870.1
22	Тэтгэврийн даатгал	95,017,597.1	145,823,749.4
23	Тэтгэмжийн даатгал	11,211,883.0	17,514,629.5
24	ҮОМШӨ-ний даатгал	9,512,231.7	8,538,705.8
25	Ажилгүйдлийн даатгал	2,038,368.9	7,917,087.5
26	Эрүүл мэндийн даатгал	20,857,416.9	32,454,698.0
27	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,893,209.3	77,824,952.3
28	Гэрэл, цахилгаан	6,141,370.8	7,861,181.3
29	Түлш, халаалт	62,231,410.5	66,674,658.0
30	Цэвэр, бохир ус	2,520,428.0	3,289,113.0
31	Хангамж, бараа материалын зардал	41,214,094.2	24,799,612.3
32	Бичиг хэрэг	13,471,300.0	9,477,250.0
33	Тээвэр, шатахуун	5,660,467.0	5,653,740.0
34	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,141,477.2	2,295,012.3
35	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	568,000.0	1,150,000.0
36	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,372,850.0	6,223,610.0

37	Эд хогшил, урсгал засварын зардал	146,613,686.0	30,560,116.0
38	Багаж, техник, хэрэгсэл	770,000.0	9,724,500.0
39	Урсгал засвар	145,843,686.0	20,835,616.0
40	Томилолт, зочны зардал	13,778,900.0	17,696,800.0
41	Дотоод албан томилолт	13,778,900.0	17,696,800.0
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,730,293.0	2,188,374.0
43	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,173,000.0	1,130,350.0
44	Даатгалын үйлчилгээ	494,250.0	500,000.0
45	Тээврийн хэрэгслийн татвар	52,700.0	10,100.0
46	Газрын төлбөр	10,343.0	12,004.0
47	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	535,920.0
48	Бараа үйлчилгээний бусад зардал	56,510,566.6	2,128,600.0
49	Бараа үйлчилгээний бусад зардал	55,248,066.6	270,000.0
50	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,262,500.0	1,858,600.0
51	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136,246,936.9	289,298,739.2
52	Бусад урсгал шилжүүлэг	39,432,660.0	234,258,154.4
53	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,191,760.0	56,906,288.4
54	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,240,900.0	-
55	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	175,351,866.0
56	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,000,000.0
57	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	55,040,584.8
58	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	50,386,130.3
59	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,654,454.4
60	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	96,814,276.9	-
61	Төвлөрүүлэх шилжүүлэг	96,814,276.9	-
62	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,501,393.6	9,838,900.0
63	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	-	9,838,900.0
64	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	9,838,900.0
65	Дотоод эх үүсвэрээр	-	9,838,900.0
66	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	9,838,900.0
67	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(9,838,900.0)
68	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,501,393.6	-
69	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	949,000.0	949,000.0
70	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	949,000.0	949,000.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	349,539,030.0	135,523,753.9	898,219,065.5	1,383,281,849.5
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	349,539,030.0	135,523,753.9	898,219,065.5	1,383,281,849.5
3	Тайлант үеийн үр дүн	-	-	(71,398,482.8)	(71,398,482.8)
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,539,030.0	135,523,753.9	826,820,582.7	1,311,883,366.7
5	2024 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	349,539,030.0	135,523,753.9	826,820,582.7	1,311,883,366.7
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	349,539,030.0	135,523,753.9	826,820,582.7	1,311,883,366.7
7	Тайлант үеийн үр дүн	-	-	(38,021,541.9)	(38,021,541.9)
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,539,030.0	135,523,753.9	788,799,040.9	1,273,861,824.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,157,347,800.0	2,106,961,669.7	50,386,130.3	97.7
2	УРСГАЛ ЗАРДАЛ	2,157,347,800.0	2,106,961,669.7	50,386,130.3	97.7
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,915,873,100.0	1,874,703,515.3	41,169,584.7	97.9
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,546,634,600.0	1,521,967,012.1	24,667,587.9	98.4
5	Үндсэн цалин	843,584,500.0	870,174,702.6	(26,590,202.6)	103.2
6	Нэмэгдэл	423,293,600.0	442,145,811.3	(18,852,211.3)	104.5
7	Унаа хоолны хөнгөлөлт	96,534,400.0	57,274,062.4	39,260,337.6	59.3

8	Урамшуулал	183,222,100.0	152,372,435.9	30,849,664.1	83.2
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	202,869,600.0	189,859,148.5	13,010,451.5	93.6
10	Тэтгэврийн даатгал	137,804,200.0	130,715,375.0	7,088,825.0	94.9
11	Тэтгэмжийн даатгал	17,516,300.0	15,731,143.4	1,785,156.6	89.8
12	ҮОМШӨ-ний даатгал	8,258,200.0	7,637,335.6	620,864.4	92.5
13	Ажилгүйдлийн даатгал	8,258,200.0	7,016,194.1	1,242,005.9	85.0
14	Эрүүл мэндийн даатгал	31,032,700.0	28,759,100.5	2,273,599.5	92.7
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,866,800.0	77,824,952.3	41,847.7	99.9
16	Гэрэл, цахилгаан	7,640,500.0	7,861,181.3	(220,681.3)	102.9
17	Түлш, халаалт	66,332,100.0	66,674,658.0	(342,558.0)	100.5
18	Цэвэр, бохир ус	3,894,200.0	3,289,113.0	605,087.0	84.5
19	Хангамж, бараа материалын зардал	25,239,400.0	24,799,612.3	439,787.7	98.3
20	Бичиг хэрэг	9,456,000.0	9,477,250.0	(21,250.0)	100.2
21	Тээвэр, шатахуун	5,662,000.0	5,653,740.0	8,260.0	99.9
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,516,500.0	2,295,012.3	221,487.7	91.2
23	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,275,000.0	1,150,000.0	125,000.0	90.2
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,329,900.0	6,223,610.0	106,290.0	98.3
25	Эд хогшил, урсгал засварын зардал	41,448,300.0	40,399,016.0	1,049,284.0	97.5
26	Багаж, техник, хэрэгсэл	20,448,300.0	19,563,400.0	884,900.0	95.7
27	Урсгал засвар	21,000,000.0	20,835,616.0	164,384.0	99.2
28	Томилолт, зочны зардал	15,746,100.0	15,656,800.0	89,300.0	99.4
29	Дотоод албан томилолт	15,746,100.0	15,656,800.0	89,300.0	99.4
30	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,054,400.0	2,188,374.0	1,866,026.0	54.0
31	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,455,400.0	1,130,350.0	1,325,050.0	46.0
32	Даатгалын үйлчилгээ	784,800.0	500,000.0	284,800.0	63.7
33	Тээврийн хэрэгслийн татвар	147,100.0	10,100.0	137,000.0	6.9
34	Газрын төлбөр	14,700.0	12,004.0	2,696.0	81.7
35	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	652,400.0	535,920.0	116,480.0	82.1
36	Бараа үйлчилгээний бусад зардал	2,013,900.0	2,008,600.0	5,300.0	99.7
37	Бараа үйлчилгээний бусад зардал	150,000.0	150,000.0	-	100.0
38	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,863,900.0	1,858,600.0	5,300.0	99.7
39	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	241,474,700.0	232,258,154.4	9,216,545.6	96.2
40	Бусад урсгал шилжүүлэг	241,474,700.0	232,258,154.4	9,216,545.6	96.2
41	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	57,256,300.0	56,906,288.4	350,011.6	99.4
42	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	181,765,900.0	175,351,866.0	6,414,034.0	96.5
43	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,452,500.0	-	2,452,500.0	-
44	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,157,347,800.0	2,106,961,669.7	50,386,130.3	97.7
45	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,157,347,800.0	2,106,961,669.7	50,386,130.3	97.7
46	Улсын төсвөөс санхүүжих	2,157,347,800.0	2,106,961,669.7	50,386,130.3	97.7
47	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	115.0	109.0	6.0	94.8
48	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	-	100.0
49	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0
50	АЖИЛЛАГСАДЫН ТОО	57.0	54.0	3.0	94.7
51	Удирдах ажилтан	6.0	3.0	3.0	50.0
52	Гүйцэтгэх ажилтан	45.0	43.0	2.0	95.6
53	Үйлчлэх ажилтан	6.0	6.0	-	100.0
54	Гэрээт ажилтан	-	2.0	(2.0)	#DIV/0!
55	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	57.0	54.0	3.0	94.7
56	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	47.0	46.0	1.0	97.9
57	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.0	8.0	2.0	80.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	ТАЙЛАНТ ОН
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	210,506,703.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	120,000.0
120007	Бусад орлого	120,000.0

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	210,386,703.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	210,386,703.9
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	208,346,703.9
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,040,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	210,506,703.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	210,506,703.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	203,852,249.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	179,302,527.9
210102	Нэмэгдэл	179,302,527.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,389,721.6
210201	Тэтгэврийн даатгал	15,108,374.4
210202	Тэтгэмжийн даатгал	1,783,486.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	901,370.2
210204	Ажилгүйдлийн даатгал	900,893.4
210205	Эрүүл мэндийн даатгал	3,695,597.5
2107	Томилолт, зочны зардал	2,040,000.0
210702	Дотоод албан томилолт	2,040,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	120,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,654,454.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,654,454.4
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,654,454.4

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын газар /цаашид Аймгийн Нийгмийн даатгалын газар гэх/ нь 2024 онд “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах,
- Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх,
- Нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлтийг хангах, уг сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт үйлчилгээний зардлыг цаг тухайд нь олгох,
- Нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагч иргэдэд шуурхай чирэгдэлгүй хүргэх,
- Үйлчилгээний чанар, хүртээмж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах,
- Даатгалын үйлчилгээнд дэвшилтэд хэлбэр, маркетингийг нэвтрүүлэх,
- Менежментийн чадавхыг бэхжүүлэх, ажилтнуудыг чадваржуулах,
- Хууль тогтоомжийг сурталчлах ажлыг шинэ шатанд гаргах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын газрын санхүүгийн үйл ажиллагаанд НДЕГ-ын Хяналт, шалгалтын газраас хяналт тавьж ажилладаг бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь НДЕГ-ын даргын 2022 онд баталсан *“Нийгмийн даатгалын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байгаа бөгөөд уг баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.*

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан *“Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.*

2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,021.6 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	949.0	949.0	-
Авлага	102.3	1,077.2	974.9
Бараа материал	16,519.3	23,098.2	6,578.9
Үндсэн хөрөнгө	1,294,414.8	1,248,839.5	(45,575.3)
Нийт хөрөнгө	1,311,985.4	1,273,963.8	(38,021.6)
Өр төлбөр	102.0	102.0	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,311,883.4	1,273,861.8	(38,021.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,311,985.4	1,273,963.8	(38,021.6)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 974.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2 албан хаагчид жилийн эцсийн урамшуулал илүү олгосонтой холбоотой байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 23,098.2 мянган төгрөг болж, 6,578.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 29,729.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, НДЕГ-аас 2,414.0 мянган төгрөгийн албан бланк, маягт, хувийн хэргийн хавтсыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан болон 25,564.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,248,839.5 мянган төгрөг болж, 45,575.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 9,838.9 мянган төгрөгийн компьютер, скайнер худалдан авсан, 8,730.6 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг дахин үнэлж орлогод авсан болон 17,425.1 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг акталсан, тайлант хугацааны элэгдлийн зардал 46,719.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,951,589.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 126,800.0 мянган төгрөгөөр бууруулан 1,824,789.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг 332,558.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгол, зохицуулалт хийж, **2,157,347.8** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 301,737.1 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 38,069.6 мянган төгрөгөөр,
- Тогтмол зардлыг 5,789.9 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 6,962.0 мянган төгрөгөөр гэх мэт нэмэгдүүлэн эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,157,347.8 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэн, гүйцэтгэлээр 2,106,961.7 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,106,961.1 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь нийт зардлын төсвийг 50,386.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,814,156.6	1,797,475.4	16,681.1	99.1
2	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	4,455.00	4,455.0	0.0	100.0
3	Өмгөөлөл хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	392.4	80.0	312.4	20.4
4	Харуул, хамгаалалтын зардал	543.0	0.0	543.0	0.0
5	Зөвлөл, хороо гишүүдийн ажлын хөлс	96,326.1	72,693.0	23,633.0	75.5
6	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	184,218.4	175,351.8	8,866.6	95.2
7	Хуульд заасан үндэслэлээр албан хаагчид олгох нөхөн олговор	2,256.3	2,256.2	0.0	100.0
8	Бусад тусламж, дэмжлэг	55,000.0	54,650.0	350.0	99.4
	Дүн	2,157,347.8	2,106,961.7	50,386.1	97.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130090401 тоот дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 208,346.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу дараах байдлаар зарцуулж, үлдэгдэл 4,654.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Төрийн захиргааны албан хаагчдад олгох орон нутагт ажилласны нэмэгдэлд 201,692.2 мянган төгрөг,
- Аймгийн шилдэг байгууллагын шагнал 2000.0 мянган төгрөгийг 20 албан хаагчид олгосон байна.

Мөн НДЕГ-аас жилийн эцэст улсын байцаагч нарын шалгалттай холбоотойгоор 2,400.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн бараа материалын бүртгэлтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 50 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийгмийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Дээрх тогтоосон материаллаг байдлын түвшинг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Иймд гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг НДГ-ын 2023 оны үйл ажиллагааны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,754,106.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **17,541.1** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн Нийгмийн даатгалын газрын мэдээлбэл зохих 28 төрлийн 168 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар *“Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тус газрын үйл ажиллагаатай холбоотойгоор 1,248.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 62,189.2 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,248.0	1	1,248.0	100
Албан шаардлага	1	62,189.2	1	62,189.2	100
Зөвлөмж	1	-	1	-	100
	1	-	1	-	100
	1	-	1	-	100
Нийт дүн	5	63,437.2	5	63,437.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар **7,734.0** мянган төгрөгийн аж ахуйн материалыг сэлбэг хэрэгслээр бүртгэж тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өглөө.

Аудитаар нийт **5,200.7** мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрч, 3,915.7 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,285.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага:

1. Албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 50.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр А.Баасансүрэн, М.Баярчимэг, М.Анударь нарт 1 сарын үндсэн цалин буюу нийт **2,940.8** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас 2 албан хаагчийн жилийн эцсийн урамшууллыг **974.9** мянган төгрөгөөр илүү тооцож олгон, авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоог урьдчилан хянаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Агуулахаас тавьж олгосон /сүлжээний болон цахилгааны утас, сүлжээний толгой гэх мэт/ нийт **900.0** мянган төгрөгийн бараа материалыг дансны үлдэгдлээр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “... удирдлага, нягтлан бодогч нь ... үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалын “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 8.21 дэх “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн байнгын системийг ашиглан бараа материалыг бүртгэнэ”, 8.21.(д) Бараа материалыг ажил, үйлчилгээнд зарцуулах үед: “Бараа материалыг ажил үйлчилгээнд ашиглахаар тавьж олгоход: Дт. Зардал /нэр төрлөөр/, Кт. Бараа материал /нэр төрлөөр/” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Хөрөнгө, бараа материалын хөдлөл өөрчлөлт бүрийг холбогдох анхан шатны баримтыг үндэслэн бүртгэл тайланд үнэн тусгаж байх.

2.1 Илрүүлэлт: НДЕГ-аас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 385.0 мянган төгрөгийн албан бланк, маягт, хувийн хэргийн хавтсыг бөөн дүнгээр зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг үндэслэн бараа материалын хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр бүртгэж байх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын ангилал буруу бүртгэсэн.	1	7,734.0			1	7,734.0			1	7,734.0	1	7,734.0
Дүн	1	7,734.0			1	7,734.0			1	7,734.0	1	7,734.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урамшуул давхардуулан олгосон	1	2,940.8			1	2,940.8						
Төлбөр тооцог урьдчилан хяналгүйгээр авлага үүсгэсэн	1	974.9			1	974.9						
Агуулахаас тавьж олгосон бараа материалыг дансны үлдэгдлээр бүртгэж, тайлагнасан	1	900.0					1	900.0				
НДЭГ-аас үнэ төлбөргүй шилжиж ирсэн материалыг бөөн дүнгээр зарлагдсан	1	385.0					1	385.0				
Дүн	4	5,200.7			2	3,915.7	2	1,285.0				